

ӨГҮҮЛЭЛ

Социализмын үеийн Монгол, Хятадын түүх судлалын харилцаа: Ойлголцол ба зөрчил (1950-иад он)**Бөхөө**

Докторант,

МУИС-ийн Түүхийн тэнхим, Улаанбаатар, Монгол Улс
bukh0204@outlook.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны дараах 10 орчим жилийн хугацаанд хоёр улс социалист орнуудын хувиар түүхэн материализмын онол хийгээд пролетарийн интернационализмын зарчмыг үзэл баримтлал болгосон ойлголцлын үндсэн дээр хамтран түүх судлалыг хөгжүүлэх гэсэн оролдлогын тухайд тусгайлан өгүүлэх болно. Чингэхдээ, 1950-иад оны эхэн хагаст материал солилцох байдлаар түүх судлалын харилцааг эхлүүлснийг тодруулан, улмаар 1950-иад оны хоёрдугаар хагаст “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг Монгол, Хятад, Зөвлөлтийн эрдэмтэд хамтран бичих төлөвлөгөөний хүрээнд Монгол-Хятадын түүх судлалын харилцаа эрчимжсэн ч тухайн цагийн олон улсын харилцааны нөхцөл байдал хийгээд хоёр талын түүхэн ойлголтын талаарх зарчмын зөрөө нь энэхүү харилцааг хөгжүүлэх явцад хэрхэн сорилт болж байсан, тэрхүү сорилтыг даван туулах гэсэн эрмэлзлэлийн тухайд архивын баримтуудад голлон тулгуурлаж, задлан шинжлэл хийсэн болно.

Түлхүүр үгс: БНМАУ, БНХАУ, түүх судлалын солилцоо, БНМАУ-ын түүхийн гурван боть, түүхэн материализм, социалист лагер



XX зууны эхэн хагаст Монголын тусгаар тогтнолыг тойрон Монгол, Хятад хоёр удаан хугацааны турш эсэргүүцлийн байдалд байсан тул талууд харилцан биенийхээ түүхийн талаар огт өөр үзэл бодлыг буй болгоод байлаа. Тухайн үед ДИУ-ын түүхчид Монгол улсыг өөрийн улсын нэг хэсэг хэмээн үзэж, Монголын тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөн нь Оросын эзэнт гүрэн, ЗХУ-ын турхиралттай холбоотой хэмээн тайлбарлаж байлаа.¹ Эсрэгээрээ Монголын тал өөрийн тусгаар тогтнолоо зүй ёсны хэмээн үзсээр байсан ба ялангуяа БНМАУ байгуулагдсаны дараа ДИУ-ын Засгийн газартай сөргөлдөхдөө Монголын ард түмний тэмцлийн ангич шинж чанарыг онцлон тэмдэглэсээр байв.²

Гагцхүү 1949 онд БНХАУ байгуулагдаж, БНМАУ ба БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон хийгээд 1950 онд БНХАУ ба ЗХУ-ын хооронд найрамдалт холбоотны гэрээ байгуулагдсны дараа л Монгол, Хятадын харилцаа зарчмын сөргөлдөөнт байдлаас ангижирч, социалист лагерын хүрээнд идэвхитэй хөгжих болсон билээ. Хоёр улс пролетарын интернационализм гэх албаны онолын дагуу эдийн засаг, соёлын талаарх хамтын ажиллагааг

өрнүүлэх болсны хүрээнд түүх судлалын харилцааг ч эхлүүлсэн юм.

Ийм түүхэн ээдрээтэй харилцааны суурь дээр Монгол, Хятад хоёр улс түүх судлалын харилцааг хэрхэн өрнүүлсэн юм бол? гэдэг нь туйлын их сонирхууштай асуудал мөн билээ.

Энэ үеийн Монгол, Хятадын түүх судлалын харилцааны талаарх тусгай судалгаа өнөөг хүртэл хийгдээгүй байна. Харин зарим судалгаа 1950-иад оны үед Монгол, Хятад, Зөвлөлтийн эрдэмтэд хамтран БНМАУ-ын түүхийг бичих гэсэн төлөвлөгөө хийгээд 1962-онд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн зэрэг асуудлуудыг хөндөж, улмаар эдгээр түүхэн үзэгдэлд дүн шинжилгээ хийхдээ тухайн үеийн Монгол, Хятадын түүх судлалын талаарх өөр өөр үзэл бодлыг илрүүлж, Монголын түүхийг тайлбарлахад Хятад-Зөвлөлтийн харилцаа хэрхэн нөлөөлж байсныг онцлон тэмдэглэсэн байна.³ Эдгээр судалгаа хэдийгээр Хүйтэн дайны үеийн зарим түүхэн асуудлаарх Монгол, Хятадын ялгаа заагийг тодруулж өгсөн нь сайшаалтай ч тус хоёр улс бие даан түүхэн асуудлаар нэгдсэн ойлголцолд хүрэхийг оролдож, 1950-иад онд хамтын ажиллагаа өрнүүлж байсныг үл тоомсорлосон нь харамсалтай.

1 МУУТА, Ф-23, Д-2, ХН-392, тал 90; 陈崇祖: 《外蒙古近世史》, 上海: 商务印书馆, 1928年; 屈燧: 《自治外蒙古》, 上海: 商务印书馆, 1918年.

2 ГХТА, Ф-5, Д-2, ХН-136, тал 86.

3 Robert A. Rupen, *Mongols of the Twentieth Century*, Bloomington: Indiana University, 1964; Robert A. Rupen, *How Mongolia Is Really Ruled*, California: Hoover Institution Press, 1979; Moris Rossabi, *China and Inner Asia: From 1368 to the Present Day*, London: Thames and Hudson, 1973.

Монгол, Хятадын түүх судлалын харилцаа эхэлсэн нь

Өмнө дурдсанчлан Монгол-Хятадын дипломат харилцаа тогтоосны дараа хоёр улсын эдийн засаг, соёлын харилцаа нь пролетарийн интернационализмд суурилсан социалист лагерын хүрээнд хөгжиж ирсэн. Хэдий Монгол ба Хятадын хооронд эртний соёлын харилцаа хязгаарлагдмал байсан ч хоёр орны удирдагчид соёлын солилцоог Монгол-Хятадын хоорондын харилцааны чухал суваг болгон ашиглахыг зорьж байсан байна.⁴ Ингээд хоёр улс 1952 онд “Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр” байгуулснаар соёлын харилцааны анхны албан ёсны үндэс суурь тавигджээ. Үүний дараа хоёр улсын соёлын солилцоо улам гүнзгийрсэн бөгөөд 1954 онд соёлын хамтын ажиллагааны механизм байгуулагдсанаар Монгол-Хятадын хооронд соёлын харилцаа тухайн үедээ дэлгэр хөгжих болж, түүх судлалын харилцаа ч мөн энэ механизмын хүрээнд явагдах болжээ.

Хэдийгээр Монгол-Хятадын харилцаа албан ёсны болж, шинэ шатанд гарсан ч түүхэн дэх сөрөг хүчин зүйлүүд тухайн үеийн хоёр орны хүмүүсийн сэтгэлгээнд нөлөөлсөөр байв. Тухайлбал, Монголын нийгэм Хятад орон, хятад хүмүүсийн талаар сөрөг үзэлтэй хэвээр байв.⁵ Үүний

зэрэгцээ БНМАУ-ыг Хятадын алдагдсан хэсэг гэдэг бодол хятадуудын дунд бас түгээмэл байсаар байв.⁶ Ийм нөхцөл байдалд хоёр тал юуны өмнө хоёр орны харилцааны түүхийг дахин тайлбарлахыг оролдов. Үүнийг 1950-иад оны эхээр хоёр улсын Засгийн газрын эмхэтгэн гаргасан товхимолд тодорхой харуулсан юм.⁷ Тэдгээрт, хоёр орны түүхэн зөрчлийг “харгис ноёрхогч ангийн хуйвалдаан”-тай холбон үзэж, харин эсрэгээрээ ард түмэн ямагт найрсаг харилцааг эрэлхийлсээр ирснийг онцолж, аугаа их Октябрийн хувьсгалын нөлөөгөөр Монгол, Хятад тус тусын хувьсгалыг хийснээр нийтлэг үзэл суртал, ангийн ашиг сонирхлыг хуваалцсан социалист лагерийн гишүүд болсон хэмээн тайлбарлажээ.

Энэхүү түүхэн тайлбар нь тухайн үед Монгол, Хятад албан ёсоор хүлээн зөвшөөрсөн марксизм, түүхэн материализмын ангич үзлийн үзэл санааны илрэл байсан бөгөөд хоёр улсын түүх судлалын харилцааны онолын үндэс суурь болсон юм.

Түүх судлалын харилцаа эхэндээ түүхэн ном зэрэг материалыг солилцох байдлаар явагдаж байв. 1950-иад оны эхээр хоёр улсын соёлын байгууллагууд хараахан шууд холбоо тогтоогоогүй байсан тул энэ ажлыг голчлон ЭСЯ-даараа дамжуулан

4 沈志华编：《俄罗斯解密档案选编：中苏关系》（kindle版5号字体），上海：东方出版中心，2015年，第20629-20676页；ГХТА, Ф-5, Д-2, ХН-136, тал 64.

5 МУУТА, Ф-1, Д-5, ХН-134, тал.1-6;

6 沈志华编：《俄罗斯解密档案选编：中苏关系》（kindle版5号字体），第18410-18415页.

7 МУУТА, Ф-1, Д-5, ХН-138, тал.1-178; 新华时事丛刊社：《蒙古人民共和国》，北京：新华印刷厂北京第一厂，1950年.

гүйцэтгэж байв. Жишээлбэл, 1953 онд Хятадын тал өөрийн ЭСЯ-аар дамжуулан Монголын талаас захиалсан номын жагсаалтад “Монголын түүх”, “Монголын хувьсгалт намын түүх”, “Эртний Монголын түүх”, “Монголын нууц товчоо” зэрэг түүхэн бүтээлүүд багтжээ.⁸ Ном тараахаас гадна, хоёр улсын ЭСЯ өөрсдөө мөн хоёр улсын эртний үеийн түүх судлалын харилцаанд тодорхой үүрэг гүйцэтгэж байжээ. Хятадад суугаа Монголын ЭСЯ-ны нэг чухал үүрэг бол түүхэн сурвалж, эд өлгийн зүйлсийг цуглуулах явдал байв.⁹ Монголд суугаа Хятадын ЭСЯ БНМАУ-ыг хятадуудад сурталчлах зорилгоор Монголын хувьсгалын түүх зэргийг багтаасан зарим ном материалыг орчуулав.¹⁰

1950-иад оны эхээр монгол, хятад түүхчид мөн өөрсдийн хувийн сонирхолоороо түүхийн асуудлаар харилцаж эхэлжээ. 1952 онд хятад түүхч Юй Юань-Ань (余元庵) Монголын ЭСЯ-аар дамжуулан Монголын ШУХ-гээс Монголын түүхтэй холбогдох судалгаандаа материал хүссэн бөгөөд тус хүрээлэнг түүний хийж байсан судалгааны тухайд санал өгөхийг хүсэж байв. Холбогдох материал ганц хувь байсан тул ШУХ ном өгөх боломжгүй байсан ч Юй Юань-Аний хүсэлтийг хүндэтгэн судалгааны бүтээлийн жагсаалтыг гаргаж хүргүүлэхдээ түүний судалгааны төлөвлөгөөний тухайд тодорхой санал дурдаагүй

байна.¹¹ Энэ нь тухайн үед хоёр улсын хооронд түүхэн материал солилцоход хязгаарлалттай байсан бөгөөд хоёр тал бие биенийхээ судалгааг шууд үнэлэхээс зайлсхийж байсныг илтгэх нэгэн жишээ мөн. Гэсэн хэдий ч тэр үеийн хоёр улсын хоорондох найрсаг уур амьсгал түүхчдэд шинэ боломжийг олгож байлаа. Жишээлбэл, 1953 онд түүхч Б.Ширэндэв МАХН-ын тухай түүхийг бичих ажилдаа Хятадын ЭСЯ-аар дамжуулан холбогдох зарим материалыг олж авсан байна.¹²

Үүнээс гадна, хоёр орны эрдэм шинжилгээний байгууллагууд түүхийн номыг багтаасан материал солилцох талаарх хамтын ажиллагаагаа эхлүүлжээ. 1951 онд Хятадын ШУА-иас Монголын ШУХ-тэй холбоо тогтоож, ном солилцох санал гаргав. Монголын ШУХ энэхүү саналыг дуртайяа хүлээн авсан бөгөөд цаашид хоёр тал эрдэм шинжилгээний ололт, туршлагыг харилцан солилцох нь чухал гэж үзэж байв.¹³ Монголын ШУХ, Хятадын ШУА нь тухайн үед хоёр улсын түүх судлалын төвүүд байсны хувьд тэдний хамтын ажиллагаа хоёр улсын цаашдын мэргэжлийн түүх судлалын харилцааны үндэс суурийг тавьсан юм. Улмаар 1950-иад оны дундуур Монгол, Хятадын хооронд жилийн соёлын хамтын ажиллагааны механизмыг байгуулсаны дараа хоёр талын түүх судлалын байгууллагууд албан ёсоор тогтмол солилцоо хийж эхлэв.

8 ГХТА, Ф-5, Д-2, ХН-117, тал 177-186.

9 ГХТА, Ф-5, Д-2, ХН-87, тал 165.

10 ГХТА, Ф-5, Д-2, ХН-117, тал 174.

11 ГХТА, Ф-5, Д-2, ХН-87, тал 42-43.

12 ГХТА, Ф-5, Д-2, ХН-117, тал 197.

13 МУУТА, Ф-23, Д-2, ХН-3, тал 47

1955 оны Монгол-Хятадын соёлын хамтын ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу хоёр орны түүхчид анх удаа харилцан айлчлал хийжээ. 1955 оны 4 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл Монголын ШУХ-гийн түүхч Ш.Нацагдорж Монголын соёлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтан Хятадад сар гаруй хугацаанд айлчлав. Энэ хугацаанд тэрбээр Бээжингийн номын сан ба Хятадын ШУА-ийн дөнгөж байгуулагдсан Түүхийн институтэд¹⁴ очиж, Монголын түүхтэй холбоотой материалуудтай танилцав.¹⁵ Ш.Нацагдорж бээр Хятадын ШУА-ийн дарга Го Можо (郭沫若) зэрэг Монголын түүхийг судалдаг хятад зарим эрдэмтэдтэй албаны болон хувийн харилцаатай

байж, Монголын түүх судлах ажилд материал цуглуулах зэргээр дэмжлэг авах амлалтыг тэднээс сонсож байсан юм.¹⁶ Чухамдаа дараа иймээрхүү хувийн харилцаа нь хоёр улсын түүх судлалын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Сарын дараа хятад түүхчид Хөү Вайлү (侯外庐), Вөн Дүзянь (翁独健) нар мөн соёлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж Монголд зочлов. Айлчлалын үеэр тэд голчлон Монголын эрдэм шинжилгээний байгууллагууд, түүх судлалын байдалтай танилцсан байна. Судлаачид ийнхүү харилцан айлчилсан нь хоёр улсын түүх судлалын харилцааг эрчимжүүлэхэд ихээхэн түлхэц болсон билээ.¹⁷

Монгол, Хятадын түүх судлалын хамтын ажиллагаа гүнзгийрсэн нь

Тухайн үеийн Монгол, Хятад хоёр улсын түүх судлалын талаар хамгийн чухал хамтын ажиллагаа бол “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох явдал байв. 1948 онд Монгол, Зөвлөлтийн түүхчид Монголын түүхийн нэгэн боть, гурван ботийг дараалан хамтран зохиохоор төлөвлөж байв. “БНМАУ-ын түүхийн нэгэн боть”-ийг 1954 онд л хэвлүүлсэн тул “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох бэлтгэх ажил 1955 оноос албан ёсоор эхэлсэн юм. Тухайн үеийн шинэ орчинд Монголын тал энэхүү зохиолыг

зөвлөлтийн эрдэмтэдтэй төдийгүй хятад эрдэмтэдтэй хамтран зохиохоор шийдсэн байна.¹⁸ Тухайн үеийн Монголын хамгийн чухал түүхэн бүтээл болохын хувьд Монголын тал энэхүү бүтээлийг зохиоход хятад түүхчдийг оролцуулахыг урьсан нь онцлог ач холбогдолтой гэж хэлж болно. Учир нь Монголын эртний түүхийн талаарх хятад баримт сурвалж болон хятад хэлний туслалцаа авах шаардлагатай байснаас гадна хоёр улс нийтлэг түүхэн онол, өөрөөр хэлбэл түүхэн материализмыг баримталсантай

14 1955 онд Хятадын ШУА Хятадын эртний түүх, дунд эртний түүх, орчин үеийн түүхийг судлах гурван эрдэм шинжилгээний институт байгуулжээ.

15 ГХТА, Ф-5, Д-2, ХН-163, тал 178-191.

16 ГХТА, Ф-5, Д-2, ХН-176, тал 23-58.

17 ГХТА, Ф-5, Д-2, ХН-164, тал 149.

18 МУУТА, Ф-23, Д-2, ХН-170, тал 56.

бас холбоотой байв. Үүнээс гадна тухайн үеийн Хятад-Зөвлөлтийн сайн харилцаа нь энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гадаад таатай орчныг бүрдүүлж өгсөн юм. Тиймээс энэ төлөвлөгөө нь пролетарийн интернационализмд суурилсан социалист лагерь дахь улс орнуудын хамтын ажиллагааны нэг сайн жишээ байсан гэж хэлж болно.

1956 оны Монгол-Хятадын Соёлын хамтын ажиллагааны жилийн төлөвлөгөөнд Монголын ШУХ, Хятадын ШУА шууд харилцаа холбоо тогтоохоор тусгагджээ.¹⁹ Иймийн тулд тухайн жилээс хоёр улс “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох талаарх хамтын ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн билээ. Энэ ажлын хүрээнд Монголын түүхч Н.Ишжамц тухайн оны 5 дугаар сарын 18-наас 11 дүгээр сарын 18-ны хооронд холбогдох сурвалж материалын байдалтай танилцах зорилгоор Хятадад зургаан сарын хугацаатай судалгаа хийхдээ Бээжин, Өвөр Монгол, Луоян, Ши-Ань, Чунчин, Юньнань, Наньжин, Шанхай зэрэг газруудад хүрч ажилласан байна. Тэрбээр очсон газруудынхаа номын санд саатаж, Мин улсын үеийн Монголын тухай нэн ховор Хятадын сурвалж бичиг зэргийг багтаасан “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг бүтээхэд чухал шаардлагатай сурвалж, материалын жагсаалтыг үйлдэн хийжээ.²⁰ Ийнхүү томиллоор ажиллах хугацаандаа тэрбээр эртний үеийн монгол хэлний баримт

сурвалжийн тухайд Хань Рүлинь (韩儒林) зэрэг хятад түүхчидтэй харилцаж байжээ. Үүнээс гадна, тэрбээр Монголын түүхийн зарим асуудлаар хятад эрдэмтдийн үзэл бодлыг тандсан байдаг. Чингэхдээ Чингис хааны талаарх хятад эрдэмтэд зөвлөлтийн эрдэмтдийн сөрөг үнэлгээнээс өөр, харьцангуй эерэг хандлагатай байгааг мэдэж авсан байна.²¹ Гурван улсын эрдэмтэд “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг хамтран зохиоход энэ мэт санал зөрөлдөөнтэй асуудал тулгарах нь гарцаагүй байсан тул түүний энэхүү ажиллагааг нөхцөл байдалтай биечлэн танилцах Монголын талын урьдчилсан бэлтгэл байжээ хэмээн үзэж болох юм.

Н.Ишжамц хятад эрдэмтэд, ялангуяа Өвөр Монгол эрдэмтэд “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох ажилд оролцох маш их сонирхолтой байгааг ч олж мэджээ. Тэрбээр буцаж ирээд Засгийн газарт өргөсөн тайландаа, нэгэн Өвөр Монгол эрдэмтэн “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохион бичихтэй уялдуулан Өвөр Монголд салбар комисс байгуулах санал гаргаж байсан зэргийг онцлон дурдаж, археологи, түүх судлалын чиглэлээр Өвөр Монголтой хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлэхдээ хятадууд ч ийм хамтын ажиллагаа өрнүүлэхийг дэмжиж буй тухай тэмдэглэсэн байдаг.²² Энэ бол тухайн цагт Монгол-Хятадын харилцаа маш дотно сайн байсан, Хятадын үндэстний бодлого харьцангуй чөлөөтэй байсан

19 ГХТА, Ф-5, Д-2, ХН-186, тал 145.

20 ГХТА, Ф-5, Д-2, ХН-185, тал 116-127.

21 МУУТА, Ф-590, Д-1, ХН-94, тал 1-24.

22 Мөн тэнд.

гэдгийг түүх судлалын хамтын ажиллагааны жишээгээр илтгэн харуулсан хэрэг болох юм.

Н.Ишжамцийн Хятадад хийсэн айлчлал ерөнхийдөө үр дүнтэй болов. Тэрбээр тайландаа Хятадад Монголын түүхтэй холбоотой материалыг археологи-этнографийн материал, уйгуржин-дөрвөлжин үсгийн дурсгал, ном судар ба гар бичмэл зэрэг гурван хэсгүүдэд хувааж дэлгэрэнгүй танилцуулжээ. Эдгээр материалууд нь Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Хятан, Монголын эзэнт гүрэн, Мин гүрэн, Чин гүрний үеийн Монголын түүхийг хамардаг бөгөөд эдгээрийн ихэнх нь тухайн үед Монголд байгаагүй түүхэн үнэт материал байжээ. Үүнээс гадна, хэдийгээр Хятадын номын худалдааны газруудад Монголын түүхтэй холбоотой ном судар ховор байсан ч тэрбээр “Елюй Чуцайн шүлгүүд”, “Хятан улсын тэмдэглэл” зэрэг ном судар, өгүүллийг хятад эрдэмтдийн туслалцаатайгаар олж авсан юм.²³

Эдгээр материалыг бүрэн ашиглахын тулд Н.Ишжамц мөн тайландаа Монголоос Хятадад оюутан сурагчид илгээх, хятад хэлний тэнхим байгуулах гэх мэт аргаар хятад хэлтэй боловсон хүчнийг сургах бэлтгэх ёстойг тусгайлан дурдсан юм.²⁴ Тэр үед Монголын түүх судлалд тулгарсан томоохон бэрхшээл бол хятад хэл, ялангуяа сонгодог хятад хэлийг сайн эзэмшсэн эрдэмтэд маш ховор байсан явдал байв. Ийм байдал нь “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг

зохиохтой холбогдуулан Монголын талыг Хятадын сонгодог сурвалж бичгийг ашиглахад хятад эрдэмтдийн туслалцаанд ихээхэн түшихэд хүргэж байсан юм. Н.Ишжамцын дэвшүүлсэн саналын дараахнаас буюу 1956 оноос эхлэн Монголын ШУХ эрдэмтдийнхээ дунд хятад хэлний хичээл тогтмол зохион байгуулах болсон ба Монголын тал эрт, дундад түүхээр ажиллах түүхчдийг бэлтгэх зорилгоор Хятадад таван хүнийг 1950-иад оны хоёрдугаар хагаст аспирантурт явуулсан билээ.²⁵

1956 онд БНХАУ түүхийн ач холбогдолтой бичиг баримт, ном хэвлэл, архивын материал, түүхэн нэрт хүний бичсэн бичиг болон метал, чулуун дээрх бичээсийн хуулбар зэрэг ховор материалуудыг гадаадад гаргахыг хориглосон “Түүхийн үнэт дурсгалт зүйлс ба номуудын экспортыг хориглох түр арга хэмжээ” (禁止珍贵文物图书出口暂行办法) -г зарласан нь “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох ажилд хэлний бэрхшээлээс гаднах давхар бэрхшээлийг тодорхой хэмжээнд учруулах болсон юм.²⁶

Гэсэн ч дээр дурдсан бэрхшээлүүдээс үл хамааран “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийн бэлтгэл ажил бүтэмжтэй явагдаж байв. 1956 онд “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиохтой холбогдуулан гурван улсын эрдэмтдийн анхдугаар зөвлөлгөөн Улаанбаатарт болжээ. Вөн Дүзянь тэргүүтэй хятад гурван түүхч энэ зөвлөлгөөнд оролцов.²⁷ Энэхүү зөвлөлгөөнд гурван

23 Мөн тэнд.

24 Мөн тэнд.

25 МУУТА, Ф-23, Д-2, ХН-350, тал 12.

26 ГХТА, Ф-5, Д-2, ХН-186, тал 8.

улсын эрдэмтэд “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг хамтран зохиох асуудлаар тохиролцоонд хүрсэн байна. Гурван улсын эрдэмтдийн хоёрдугаар зөвлөлгөөн 1957 оны 12 дугаар сард Москва хотноо болоход гурван улсын эрдэмтэд “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох ажлын төлөвлөгөөний талаар хэлэлцсэнээс гадна Монголын түүхийн талаарх илтгэлүүд тавьсан юм.²⁸

Дээрх хоёр зөвлөлгөөнд оролцсон хятад түүхч Хань Рүлинь нутагтаа буцаж ирээд “БНМАУ-ын түүхийн гурван боть” зохиолыг бичих тэрхүү төслийг хэрэгжүүлж чадах эсэх асуултад хариулахдаа “... түүхэн

материалд асуудал байхгүй. Харин зарим түүхэн асуудлыг ярилцах шаардлагатай. Ялангуяа түүхэн бие хүмүүсийг үнэлэх талаар гурван улсын эрдэмтэд өөрсдийн гэсэн үндэстний мэдрэмж, үзэл бодолтой байдаг... Үүнийг түүхэн материал, түүхэн үнэнд тулгуурлан түүхэн материализмын үүднээс шийдвэрлэх хэрэгтэй” хэмээн хариулж байжээ.²⁹ Түүний хэлсэн үгнээс бид хэдийгээр гурван улсын эрдэмтэд ангийн түүхийн үзэл баримтлалыг онцолсон боловч үнэн хэрэгтээ үндэстний асуудлын тухайд санал зөрөлдөөнтэй байсныг тодорхой харж болох байна.

Монгол, Хятадын түүх судлалын харилцаа саарсан нь

1958 он бол Монгол, Хятадын соёлын солилцооны оргил үе гэж хэлж болно. Тус жилд хоёр улс “Соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр” байгуулав. Энэхүү хэлэлцээрт хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллагууд шинжлэх ухааны талаар ололт амжилтаа харилцан солилцоно гэж тусгайлан заажээ.³⁰ Гэхдээ энэ хэлэлцээрийг боловсруулах явцад Монгол-Хятадын “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийн талаарх хамтын ажиллагаа өөрчлөгдсөн юм.

2 дугаар сарын 5-ны өдөр Бээжин хотноо Монголын Соёлын сайд С.Сосорбарам айлчлах үеэрээ Хятадын Соёлын яамны дэд сайд болох Шя Янь (夏衍), Жан Жышян (张致祥) нартай

уулзахад Хятадын тал “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг шууд бичих ажилд хятад эрдэмтэдийг оролцуулахаас татгалзах болсноо доорх шалтгааныг дурдан илэрхийлжээ. Үүнд, 1. Манай улсад их гүрний дээрэнгүй үзэл санаа байдаг. Бид түүнтэй тэмцэл явуулж байна. 2. Түүх бичнэ гэдэг бол тэр улсын туулж өнгөрүүлсэн түүхэн явдлыг дэс дараатай, зөв дүгнэлттэй бичих явдлыг шаардана... Гэтэл манай хүмүүсийн дотор түүхийн зарим чухал асуудлаар... маргаантай талууд гардаг... Манай улс нь олон ястан үндэстэнтэй болохоор бичихэд амар хялбар биш юм гэжээ. Уулзалтын үед Шя Янь Вьетнам улс урьд бас өөрийн түүхийг бичих ажилд Хятадын талыг

27 ГХТА, Ф-5, Д-2, ХН-185, тал 231.

28 陈得芝等编:《朔漠情思——历史学家韩儒林》,南京:南京大学出版社,2000年,第14页.

29 Мөн тэнд, тал 52.

30 МУУТА, Ф-4, Д-23, ХН-362, тал 36.

оролцуулахаар хүсч байсан ч Хятадын тал эцэст нь тус хоёр улс түүхэндээ муу харилцаатай үе байсныг үндэслэн Вьетнамын талын саналыг хүлээн зөвшөөрөөгүй гэдгийг мөн онцлон дурдсан байна.³¹

Чухамдаа энэ шийдвэрийг Хятадын дээд түвшний удирдагчид гаргасан юм. Энэ асуудлаар Лю Шаочи (刘少奇): “Бүх ардчилсан орнууд хэдийгээр марксизм-ленинизм ба интернационалист үзлийн талаар адил боловч... хэлбэр маягийн хувьд тусгаар улсууд юм. Энэ учраас эдгээр орнуудын хооронд зөрүүтэй зүйлүүд байх ёстой” хэмээн хэлж байв.³² Эдгээр баримтуудаас харахад, Хятадын тал хоёр улсын түүхэн ойлголтын талаарх ялгаатай байр суурийг илэн далангүй тэмдэглэсэн байна. Гэхдээ яагаад Хятадын тал энэ үед ийм шийдвэрт хүрэв гэдэг асуулт гарч ирж байна. Энэ асуултад хариулахын тулд тухайн үеийн Хятад-Зөвлөлтийн харилцаа, Хятадын үндэстний бодлогын өөрчлөлтийг эрхбиш хөндөх хэрэгтэй болно.

1956 онд гэхэд Хятадын удирдагч Мао Зэдун социалист байгуулалтын талаар Зөвлөлттэй өрсөлдөх санаатай болсон байлаа. 1957 оны 11 дүгээр сард Олон улсын Коммунист - Ажилчны намуудын зөвлөгөөн дээр Мао Зэдун Зөвлөлтийн бодлогоос өөр хувьсгалт тэмцлийн шугамыг илэрхийлж байв.³³ 1958 он гэхэд Хятад-Зөвлөлтийн

зөрөлдөөн илүү тод харагдах болсон юм. Ийм нөхцөлд “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг хамтран зохиох ажилд Хятадын тал биечлэн оролцсоор байвал ойлголцолд хүрэхэд бэрхшээлтэй тулгарч магадгүй байдал үүсч байв. Үүнээс гадна, өмнө дурдсанчлан Зөвлөлт, Монголын эрдэмтэд “БНМАУ-ын түүхийн нэг боть”-ийг хамтран зохиосон нь Монгол дахь анхны марксизм-ленинизмын түүхэн бүтээл хэмээн үнэлэгдэж байлаа.³⁴ Үнэндээ энэхүү өндөр үнэлэгдсэн бүтээлийн дөрөвний гурвыг зөвлөлтийн эрдэмтэд шууд бичжээ.³⁵ Хэдийгээр энэхүү хамтын ажиллагааг мэддэг байсан ч Хятадын тал аливаа улс бусдын түүхийг зохиоход оролцох нь тохиромжгүй гэсэн санааг илэрхийлсэн юм. Тийм учраас Хятадын тал Зөвлөлт шиг бусад улс орны түүхийг бичихэд шууд оролцдоггүй, улс орнууд өөрсдөө өөрийнхөө түүхийг бичих ёстой гэсэн зарчмын байр суурийг илэрхийлж, Монголын талд эерэг сэтгэгдэл үлдээхийг оролдсон байж болох магадлалтай юм. Үүнийг мөн Хятад, Зөвлөлтийн өрсөлдөөнд Хятадын тал Монгол зэрэг социалист хөрш орнуудыг өөрийн талд татах гэсэн нэгэн арга хэмжээ хэмээн ойлгож болно.

Нөгөө талаар Баруунтны эсрэг тэмцлийн нөлөөнд Хятадын үндэстний бодлого 1957 оны хоёрдугаар хагасаас өөрчлөгдөж эхэлсэн юм.

31 МУУТА, Ф-4, Д-23, ХН-362, тал 33-35.

32 Мөн тэнд.

33 沈志华编:《中苏关系史纲:1917-1991年中苏关系若干问题再探讨(增订版)》(kindle版5号字体),社会科学文献出版社,2016年,第4760-4765,4627页.

34 МУУТА, Ф-23, Д-2, ХН-130, тал.18.

35 Д.Өлзийбаатар, “Үзэл сурталын үзгэн дороос түүх мэндэлсэн түүх”, eagle news, 2021 оны 6 дугаар сарын 10-нд үзсэн, http://eagle.mn/r/37865?fbclid=IwAR3B5YmgJ3XSs7IFag8_-MD-5-SxL45-ujGvMHaAaKojGaFIZeK0hBVGePA

Үүнд Хятадын засгийн газар цөөн тоот үндэстнүүдийг хан үндэстэнтэй нийлүүлэхийг онцолж, үндэстний бүс нутагт “орон нутгийн үндсэрхэг үзэл”-ийг шүүмжлэх кампанийг өрнүүлжээ.³⁶ Үндэстний бодлогын өөрчлөлтийн ийм эмзэг үед Өвөр Монголын түүхийг хамарсан “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиоход оролцох нь Хятадын үндэстний шинэ бодлогыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж болзошгүй байлаа.

Дээрх хүчин зүйлсийн нөлөөгөөр Хятадын тал “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох ажилд өөрийн эрдэмтдээ гар бие оролцуулахаас татгалзах болсон билээ. Гэхдээ Хятадын тал сурвалж материал хангах талаар үргэлжлүүлэн тусламж үзүүлэхээ амласан тул “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох хамтын ажиллагаанаас хараахан бүрмөсөн татгалзаагүй гэсэн үг байлаа.³⁷ Тиймээс 1959 онд Хятадад айлчилсан Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд түүхч Ш.Нацагдорж, Ч.Далай нар багтан очихдоо, найрамдлын нийгэмлэгийн харилцааны ажлаас гадна “БНМАУ-ын түүхийн гурван боть”-той холбоотой материал цуглуулах ажлыг үргэлжлүүлэн хийсээр байсан юм.³⁸ Түүнчлэн хятад түүхч Вөн Дүзянь 1959 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохиогдсон Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их

хуралд ирж оролцсон юм. Энэ үеэр тэрбээр “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг зохиох асуудлаар Монголын эрдэмтэдтэй ярилцаж, уг бүтээлийг бичихэд чухал шаардагдаж буй хятад сурвалж баримтуудыг олж авах болон орчуулга хийхэд Хятадын талаас дэмжлэг хүссэн монголчуудын саналыг холбогдох байгууллагад дамжуулахаа илэрхийлж байлаа.³⁹

Дээр дурдсан Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал нь Монгол-Хятад хоёр улсын соёлын солилцооны тухайн жилийн чухал үйл явдал төдийгүй хурлын уур амьсгал нь Монгол, Хятадын түүх судлалын харилцаа гадаад нөхцөл байдлын шалтгаанаас хэрхэн саатах болсныг илтгэн харуулсан юм. Энэ хуралд социалист лагерийн эрдэмтдээс гадна Энэтхэг, Их Британи, АНУ зэрэг капиталист орнуудын эрдэмтэд мөн оролцов.⁴⁰ Тухайн үед Төвөдийн хэрэг явдал хийгээд хилийн мөргөлдөөнөөс болж Хятад-Энэтхэгийн харилцаа маш хурц байдалд байсан юм. Гэтэл Энэтхэгийн эрдэмтэн Рагху Вира илтгэл тавихдаа Төвөд, Хятадыг ижил түвшинд зэрэгцүүлэн дурдсан нь Хятадын төлөөлөгчдийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарав. Зохион байгуулагч Монголын талын зуучлалаар эцэстээ Энэтхэг эрдэмтэн Төвөдийг Хятадын нэг хэсэг хэмээн бичихээр тогтсоноор хурлын уур амьсгал эерэж байжээ.⁴¹ Үнэн хэрэгтээ энэхүү зөрчил нь Зөвлөлт,

36 毛里和子『周縁からの中国民族問題と国家』東京大学出版会，1998年，第102-107頁。

37 МУУТА, Ф-4, Д-23, ХН-362, тал 33-35.

38 МУУТА, Ф-276, Д-2, ХН-204, тал 23-26.

39 МУУТА, Ф-564, Д-1, ХН-42, тал 3-11.

40 Ш. Бира, Э. Пүрэвжав. *Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал*, УБ: “Бемби сан” ХХК, 2009, тал 31-43.

41 МУУТА, Ф-23, Д-2, ХН-313, тал 29-31.

Хятадын зөрчилдөөнийг давхар илэрхийлж байсан билээ. ЗХУ нь Хятад-Энэтхэгийн сөргөлдөөнд Энэтхэгийг дэмжих хандлагатай болоод байсан юм.

1960-аад оны дундуур Зөвлөлт, Хятадын зөрчилдөөн илэрхий хурцадахад Монголын тал энэхүү үл эвлэрэх нөхцөл байдалд Зөвлөлтийг

түших бодлогыг эргэлт буцалтгүй хэрэгжүүлсэн билээ. Хэдийгээр Монгол, Хятадын хоёр тал хүчин чармайлт гаргавч олон улсын түвэгтэй орчин нь “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг хамтран бичих гэсэн оролдлогийг нэгмөсөн үгүйсгэсэн билээ.

Дүгнэлт

1950-иад онд Монгол, Хятад хоёр улс түүхийн салбарт хамтран ажиллах гэсэн оролдлогыг дараах байдлаар дүгнэж болохоор байна.

Нэг. Монгол, Хятад хоёр улс социалист лагерийн хүрээнд харилцаагаа шинэ шатанд гаргаснаар түүхэндээ анх удаа маш их зөрөлдөөнт талбар болох түүх судлалын хамтын ажиллагааг богино хугацаанд тодорхой хэмжээнд өрнүүлж чадсан байна. Чингэхдээ энэхүү хамтын ажиллагаа тухайн үеийн үзэл суртлын дагуу пролетарийн интернационализмын онолын удирдамжаар хэрэгжиж байжээ. Хэдийгээр өөр өөрийн түүхэн хандлага асар их зөрөлдөөнтэй байсан ч нэгэнт байгуулсан найрамдалт харилцаагаа хадгалах гэсэн асар их хүчин чармайлтыг талууд гаргаснаараа хоёр улсын харилцааны түүхэнд дэвшилтэд үүрэг гүйцэтгэсэн хэмээн үзэж болох юм.

Хоёр. Энэхүү хамтын ажиллагаа түүхэн материал солилцох замаар эхэлсэн ба “БНМАУ-ын түүхийн гурван боть”-ийг Монгол, Зөвлөлт, Хятад гурван улс хамтран зохиохоор тохиролцсон нь Монгол, Хятадын түүх судлалын хамтын ажиллагааг

бодит эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны түвшинд хүргэжээ. Монголын тал энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монголын түүхтэй холбогдох олон чухал хятад материалыг цуглуулж, түүх судлалын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах олон чадварлаг мэргэжилтнийг бэлтгэж завдсан байна. Энэ нь хожим Монголын түүхийн судалгааг хөгжүүлэхэд маш их ач холбогдолтой болсон юм. Хятадын тал мөн энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монгол, Зөвлөлтийн эрдэмтэдтэй эрдэм шинжилгээний солилцоо хийж, өөрийн эрдэмтдийн Монголын түүх судлалын талаарх ололтыг танилцуулснаар энэ салбарт өөрийн нэр хүндээ тодорхой хэмжээгээр дээшлүүлжээ.

Гурав. 1950-иад оны сүүлчээс хоёр улсын шууд харилцаанаас үл шалтгаалан олон улсын нөхцөл байдлын нөлөөллөөс голлож, түүх судлалын хамтын ажиллагааны эрч хүч саарсан ч хэсэг хугацаанд үргэлжилсээр байсан ба гагцхүү 1960-аад оны эхнээс улам хурцдах болсон үзэл суртлын зөрчилдөөнд энэхүү харилцаа эцэстээ бүрэн тасалдсан байна.

Ашигласан материал

Архивын баримт, сурвалж

1. МУУТА, Ф-1, Д-5, ХН-134, тал 1-6. Хятадын Элчин сайд Цзи Я-тай, ГЯЯ-ны сайд Ламсүрэнгэй уулзаж ярилцсаны өдрийн тэмдэгдэл.
2. МУУТА, Ф-4, Д-23, ХН-362, тал 33-35. БНХАУ-ын Соёлын яамны орлогч сайд Ся Янь, Чжан Чжи-сян нар БНМАУ-ын Соёлын яамны сайд Сосорбарамтай уулзсан тухай.
3. МУУТА, Ф-23, Д-2, ХН-3, тал 47. ШУХ-гийн тэргүүлэгчдийн 1951 оны 7-р хурлын тогтоол.
4. МУУТА, Ф-23, Д-2, ХН-130, тал 11-27. ШУХ-гийн Түүхийн кабинетын 1954 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлтийн тухай тайлан.
5. МУУТА, Ф-23, Д-2, ХН-350, тал 7-16. Монголын түүх судлалын 3 жилийн төлөвлөгөөний биелэлт.
6. МУУТА, Ф-23, Д-2, ХН-392, тал 81-95. Чингис хааны судалгааны тухай.
7. МУУТА, Ф-276, Д-2, ХН-204, тал 23-26. Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн төлөөлөгчид Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгийн урилгаар БНХАУ-д зочилсон тухай товч тайлан.
8. МУУТА, Ф-564, Д-1, ХН-42, тал 3-11. Монголын түүхийн гурван боть зохиолыг хамтран бичих асуудлаар Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн дарга Д.Цэвэгмид Хятадын түүхч Вөн Дужянь-ийг хүлээн авсан уулзалтын ярианы тэмдэглэл.
9. МУУТА, Ф-590, Д-1, ХН-94, тал 1-24. БНХАУ-ын нутаг дэвсгэрт байгаа Монголын түүхийн холбогдолтой баримт материалыг үзэж судалсан тухай ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Ишжамцын тайлан.
10. ГХТА, Ф-5, Д-2, ХН-87, тал 42-43. Монголын түүхийн холбогдолтой материал хүссэн Хятадын түүхч Юй Юань-Аний захидалтай холбогдуулан Шинжлэх ухааны хүрээлэнгээс БНХАУ-д суугаа Элчин сайд Б.Жаргалсайханд явуулсан албан бичиг.
11. ГХТА, Ф-5, Д-2, ХН-117, тал 177-186. 由蒙古人民共和国订购书单籍 (Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас захиалах номын жагсаалт).
12. ГХТА, Ф-5, Д-2, ХН-136, тал 63-92. БНМАУ ба БНХАУ-ын хооронд байгуулагдсан Эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээрийн тухай справка.
13. ГХТА, Ф-5, Д-2, ХН-163, тал 178-191. БНМАУ-аас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны 1955 онд гүйцэтгэсэн соёлын харилцааны ажлын тайлан.

14. ГХТА, Ф-5, Д-2, ХН-164, тал 137. Хятадын Соёл, шинжлэх ухааны төлөөлөгчдийн тухай.
15. ГХТА, Ф-5, Д-2, ХН-176, тал 23-58. БНМАУ-аас Хятад Ард Улсад явсан соёлын төлөөлөгчдийн тавих тайлан илтгэл.
16. ГХТА, Ф-5, Д-2, ХН-185, тал 231. 1956 оны Монгол, Хятадын Соёлын хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлт.
17. ГХТА, Ф-5, Д-2, ХН-186, тал 7-8. 禁止珍贵文物图书出口暂行办法 (Түүхийн үнэт дурсгалт зүйлс ба номуудын экспортыг хориглох түр арга хэмжээ)

Эрдэм шинжилгээний ном, өгүүлэл

1. Rossabi, Moris, *China and Inner Asia: From 1368 to the Present Day*, London: Thames and Hudson, 1973.
2. Rupen, Robert A, *Mongols of the Twentieth Century*, Bloomington: Indiana University, 1964.
3. Rupen, Robert A, *How Mongolia Is Really Ruled*, California: Hoover Institution Press, 1979.
4. Ш.Бира, Э.Пүрэвжав. *Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал*, УБ: “Бемби сан” ХХК, 2009.
5. Д.Өлзийбаатар. “Үзэл суртлын үзгэн дороос түүх мэндэлсэн түүх”, eagle news, 2021 оны 6 дугаар сарын 10-нд үзсэн. http://eagle.mn/r/37865?fbclid=IwAR3B5YmgJ3XSs7lFag8_-MD-5-SxL45-ujGvMHaAaKojGaFIZeK0hBVGePA
6. 青木雅浩『モンゴル近現代史研究（1921-1924年）』早稲田大学出版部，2011年. Аоки Масахиро. *Монголын орчин үеийн түүх судлал (1921-1924 он)*, Васедагийн их сургуулийн хэвлэлийн газар, 2011
7. 毛里和子『周縁からの中国民族問題と国家』東京大学出版会，1998年. Маори Казуко. *Үндэстний бүс нутгийн өнцгөөс Хятадын үндэстний асуудал, улс орныг судалсан нь*, Токиогийн их сургуулийн хэвлэлийн газар, 1998.
8. 毕奥南：《中蒙国家关系历史编年（1949-2009）》，黑龙江教育出版社，2013年. Б.Онон, *Хятад-Монголын харилцааны түүхийн он дараалал (1949-2009)*, Хармөрөн мужийн боловсролын хэвлэлийн газар, 2013.
9. 陈得芝等编：《朔漠情思——历史学家韩儒林》，南京：南京大学出版社，2000年. Чэнь Дэжи нар. *Умардын цөлийн сэтгэл санаа-Түүхч Хань Рүлинь*, Нанжин: Нанжин их сургуулийн хэвлэлийн газар, 2000.
10. 陈崇祖：《外蒙古近世史》，上海：商务印书馆，1928年. Чэнь Чунзу. *Гадаад Монголын сүүлийн үеийн түүх*, Шанхай: Арилжааны хэвлэлийн газар, 1928.

11. 屈燧: 《自治外蒙古》, 上海: 商务印书馆, 1918年. Чу Ши. *Автономит Гадаад Монгол*,
12. Шанхай: Арилжааны хэвлэлийн газар, 1918.
13. 沈志华编: 《中苏关系史纲: 1917-1991年中苏关系若干问题再探讨 (增订版)》 (kindle版5号字体), 社会科学文献出版社, 2016年. Шэн Жихуа. *Хятад-Зөвлөлтийн харилцааны товчоон: 1917-1991 оны хоорондох Хятад-Зөвлөлтийн харилцааны зарим асуудлыг эргэн харах нь (нэмж засварласан хэвлэл)*, Нийгмийн ухааны сурвалж бичгийн хэвлэлийн газар, 2016.
14. 沈志华编: 《俄罗斯解密档案选编: 中苏关系》 (kindle版5号字体), 上海: 东方出版中心, 2015年. Шэн Жихуа. *Нууцлалаас гаргасан Оросын архивын баримтийн түүвэр: Хятад-Зөвлөлтийн харилцаа* (kindle №5 фонт), Шанхай: Дорно дахин хэвлэлийн газар, 2015.
15. 新华时事丛刊社: 《蒙古人民共和国》, 北京: 新华印刷厂北京第一厂, 1950年. Синьхуагийн цагийн байдлын цуврал, *Бүгд Найрамдах Монгол Ард Улс*, Бээжин: Синьхуа хэвлэлийн газрын Бээжингийн 1-р үйлдвэр, 1950.
16. 张启雄: 《全蒙统一运动: 喀尔喀独立的另类观点》, 蒙藏委员会编: 《蒙藏专题研究丛书之一一〇》, 台北: 蒙藏委员会, 2001年. Жан Чишюн. “Бүх Монголын нэгдэх хөдөлгөөн: Халхын тусгаар тогтнолын талаархи өвөрмөц үзэл бодол”, Монгол-Төвөдийн хороо: *Монгол ба Төвөдийн тусгай судалгааны цуврал 110 дугаар*, Тайпей: Монгол-Төвөдийн хороо, 2001.

Mongolian-Chinese Exchanges in History Studies during the Socialist Period: Mutual Understanding and Divergence (the 1950s)

Bu He

*Ph.D student, Department of History,
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia
bukh0204@outlook.com*

Abstract: *This paper studies the attempts of the MPR and the PRC to promote historical exchanges in the 1950s based on their shared ideology of proletarian internationalism and historical materialism. Specifically, this research analyzes the initial historical exchanges between the two countries in the form of material exchange in the early 1950s, and further discusses about the cooperation between Soviet, Mongolian and Chinese scholars to compile a three-volume Mongolian history in the second half of the 1950s, which pushed the Mongolian-Chinese historical exchanges to a new level. Meanwhile, the research also takes into account the influence of Sino-Soviet relations and historical differences between Mongolia and China on their historical exchanges, especially the cooperation in compiling three-volume Mongolian history. Archival documents in Mongolian and Chinese languages preserved in Mongolia are used as the main research materials for this paper.*

Keywords: *the MPR, the PRC, historical exchanges, three volumes of Mongolian history, historical materialism, Socialist Bloc*

<i>The day of submission:</i>	2021.06.10
<i>Completion of review:</i>	2021.06.21
<i>Final decision for acceptance:</i>	2021.06.30